

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол саналын шийдвэрлэлтийн мэдээ /2022 оны 1 дүгээр улирлын байдлаар/

2022.04.05

Арвайхээр

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагад 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 6975 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс хүсэлт 6768 буюу 97.0 хувь, гомдол 177 буюу 2.5 хувь, санал 30 буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 6975 өргөдөл, гомдол, санал ирсний 6736 буюу 96.57 хувь нь шийдвэрлэгдсэн, 2420 буюу 11.72 хувь нь бусад байгууллагад шилжүүлж хариуг хүргүүлсэн, 238 буюу 3.41 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Хуулийн хугацаа хоцроож хариу хүргүүлсэн өргөдөл, гомдол, санал 8 буюу 0.1 хувийг эзэлж байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ирсэн өргөдөл, гомдол, саналыг агуулгаар нь авч үзвэл нийгмийн халамжтай холбоотой өргөдөл, гомдол, санал хамгийн их буюу 3328 ирсэн бөгөөд нийт ирсэн өргөдөл, гомдол, саналын 47.8 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн улиралд иргэдээс хүүхдийн мөнгөн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах хүсэлт авч эхэлсэнтэй холбоотой юм.

График



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

СУМЫН ЗАСАГ ДАРГА, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлд:

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар “Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагын дарга нарт даалгав.

1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хариу өгч, шийдвэрлэлтийг байгууллага болон иргэдэд ил тод мэдээлэх,

2. Сум, агентлагийн удирдлагууд “Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээ, тайланг улирал бүр албажуулж танилцуулгын хамт хугацаанд нь ирүүлж байх

3. “Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээний чанар, бодит байдалд анхаарч ажиллах үүднээс аймгийн хэмжээнд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайланд цахим программ нэвтрүүлэх чиглэлээр судлах, аймгийн хэмжээнд өргөдөл гомдол шийдвэрлэлтийн журмыг шинэчлэн боловсруулах талаар судалж танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Сайнбилэгт үүрэг болгосон.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ /НЭГТГЭЛ/

2022.04.05

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн		
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	101	74	40	0	27	73.3%
2	Үйлчилгээний нэгдсэн төв 7032-1111	119	115	119	1	3	96.6%
3	Агентлаг	562	518	6	7	44	92.2%
4	Сумд	6193	6029	183	0	164	97.4%
	Дүн	6975	6736	348	8	238	96.6%
	Хувь	100.0%	96.57%		0.1%	3.41%	

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ /ХЭЛБЭРЭЭР/

2022.04.01

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	101	93	8	0	0	0
2	Агентлаг	562	490	7	55	10	0
3	Сум	6193	4453	1136	308	296	0
4	Үйлчилгээний нэгдсэн төв 7032-1111	119	1	0	118	0	0
	Дүн	6975	5037	1151	481	306	0
		100.0%	72.2%	16.5%	6.9%	4.4%	0.0%

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛЫН АГУУЛГА /ХУВИАР/

2022.04.05

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдол саналд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 6975 ирсэн байна.	хүсэлт	6768	97.0%
		гомдол	177	2.5%
		санал	30	0.4%
	Нийгмийн халамжийн үйлчилгээ		3328	47.8%
	Иргэний бүртгэл, мэдээлэл		604	8.7%
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх		323	4.6%
	Ажилд орох, чөлөөлүүлэх		554	7.9%
	Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн		449	6.4%
	Хөдөлмөр эрхлэлт		128	1.8%
	Материал, мөнгөн тусламж хүссэн		38	0.5%
	Шилжилт хөдөлгөөн		137	2.0%
	Сургууль курст суралцах		120	1.7%
	Нийгмийн даатгал		508	7.3%
	Гэр, орон сууц хүссэн		7	0.1%
	Бусад		779	11.2%
- Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсанд нийт 119 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэнээс 115 буюу 96.6 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна.				